




**САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО**



**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН  
2018 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТОЙМ**



**Улаанбаатар хот**

**2018 он**

**АГУУЛГА**

<b>1. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>	<b>3</b>
1.1. Зах зээлийн үнэлгээ	3
1.2. Үнэт цаасны зах зээлийн индексүүд	4
<b>2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД</b>	<b>4</b>
2.1. Хувьцаат компаниуд	4
2.2. Зохицуулалттай этгээд	7
<b>3. ЗАХ ЗЭЭЛ ДЭХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭРЭЛТ БА НИЙЛҮҮЛЭЛТ</b>	<b>9</b>
3.1. Хөрөнгө оруулагчдын данс ба арилжааны бүтэц	9
3.2. Үнэт цаасны арилжаа	10
3.2.1. Хувьцааны арилжаа	10
3.2.2. Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-ны арилжаа	11
3.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа	11
3.4. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа	11

## ЗУРАГ

Зураг 1. Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/ .....	3
Зураг 2. ЗЗҮ-г ДНБ-нд харьцуулсан байдал .....	3
Зураг 3. Хөрвөх чадварын түвшин.....	4
Зураг 4. ТОП-20 индекс .....	4
Зураг 5. Хувьцаат компанийн тоо .....	4
Зураг 6. Хороонд бүртгэлтэй хувьцаат компани, өмчийн хэлбэрээр .....	5
Зураг 7. Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хувьцаат компани, өмчийн хэлбэрээр..	5
Зураг 8. Хувьцаат компанийн хувьцааны бүтэц, тэрбум ширхгээр.....	5
Зураг 9. Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан хувьцаат компанийн тоо.....	6
Зураг 10. Санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд ирүүлсэн компанийн тоо .....	6
Зураг 11. Ногдол ашиг тараасан хувьцаат компанийн тоо .....	6
Зураг 12. Тараасан ногдол ашгийн үнийн дүн /тэрбум төгрөг/ .....	7
Зураг 13. Мэргэжлийн оролцогчдын тоо, тусгай зөвшөөрлийн чиглэлээр.....	7
Зураг 14. Нийт хөрөнгийн дүнг мэргэжлийн оролцогчдын тоотой харьцуулсан байдал.....	8
Зураг 15. Мэргэжлийн оролцогчдын тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал.....	8
Зураг 16. Үнэт цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэгч байгууллагын тоо .....	9
Зураг 17. Хөдөө аж ахуйн түүхий эдийн брокер .....	9
Зураг 18. ҮЦТХТ-д шинээр нээгдсэн дансны тоо.....	9
Зураг 19. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь.....	10
Зураг 20. Үнэт цаасны арилжааны үзүүлэлт .....	10
Зураг 21. Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/ .....	10
Зураг 22. ЗГҮЦ-ны зах зээлийн арилжааны дүн ба нийт арилжаанд эзлэх хувь .....	11
Зураг 23. Ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ҮЦТХТ-д бүртгэгдсэн) гаргасан байдал .....	11
Зураг 24. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны үнийн дүн /тэрбум төгрөг/.....	12
Зураг 25. МАРИХ индекс .....	12

## ХАВСРАЛТ


Хавсралт 1. Зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүд .....	13
Хавсралт 2. Үнэт цаасны зах зээлийн оролцогчид.....	13
Хавсралт 3. Зах зээл дэх бүтээгдэхүүний эрэлт ба нийлүүлэлт .....	14

## 1. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### 1.1. Зах зээлийн үнэлгээ

2018 оны хагас жилийн байдлаар байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК болон “Монголын үнэт цаасны бирж” ХК-ийн хувьцааны зах зээлийн үнэлгээний нийлбэр дүн 2,484.9 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 987.3 тэрбум төгрөг буюу 65.9 хувиар өссөн үзүүлэлт юм.


Зураг 1. Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2018 оны хагас жилийн байдлаар ЗЗҮ-г 2017 оны эцсийн үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэрлэсэн ДНБ-ий хэмжээтэй харьцуулахад 8.9 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2.6 пунктээр өссөн үзүүлэлт юм.


Зураг 2. ЗЗҮ-г ДНБ-нд харьцуулсан байдал



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ЗЗҮ-нд хувьцааны арилжааны үнийн дүнг харьцуулж тооцсон зах зээлийн идэвхийг харуулах хөрвөх чадварын үзүүлэлт нь 2.0 хувь байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 пунктээр өссөн үзүүлэлт юм.

Зураг 3. Хөрвөх чадварын түвшин




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

### 1.2. Үнэт цаасны зах зээлийн индекс

Тайлант хугацаанд ТОП-20 индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 57.7 хувиар өсөж 19,961.5 нэгж болсон бөгөөд индексийн дээд үзүүлэлт 21,737.7 нэгж, доод үзүүлэлт 18,861.4 нэгж, дундаж үзүүлэлт 20,388.6 нэгж байна.

Зураг 4. ТОП-20 индекс




Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

## 2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

### 2.1. Хувьцаат компаниуд

2018 оны хагас жилийн байдлаар 303 хувьцаат компани Хороонд бүртгэлтэй байна. Энэ хугацаанд 3 компани үнэт цаасаа анх удаа олон нийтэд санал болгон гаргасан.


Зураг 5. Хувьцаат компанийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хороонд бүртгэлтэй хувьцаат компаниудыг өмчийн хэлбэрээр нь авч үзвэл, 253 хувьцаат компани буюу 83 хувь нь хувийн өмчийн хэлбэртэй байна.


**Зураг 6. Хороонд бүртгэлтэй хувьцаат компани, өмчийн хэлбэрээр**



*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Арилжаа эрхлэх байгууллагуудад бүртгэлтэй хувьцаат компаниудыг өмчийн хэлбэрээр нь авч үзэхэд 221 хувьцаат компанийн 190 буюу 86 хувь нь хувийн өмчийн хэлбэртэй байна.


**Зураг 7. Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хувьцаат компани, өмчийн хэлбэрээр**



*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Хувьцаат компаниудыг өмчийн хэлбэрээр нь авч үзэхэд 83-86 хувь нь хувийн өмчит байсан бол хувьцааны хэмжээгээр харьцуулж үзэхэд 73 хувь нь хувийн өмчид харьяалагдаж байна.


**Зураг 8. Хувьцаат компанийн хувьцааны бүтэц, тэрбум ширхгээр**



Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК


Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/-ын гаргасан зохицуулалтын гурван үндсэн зорилгод зохицуулагч байгууллага ил тод, үр ашигтай, өрсөлдөөн бүхий зах зээлийн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай гэж үзсэн байдаг. Манай өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд мэдээлэл тайлагналын ил тод байдал гэдэгт санхүүгийн болон үйл ажиллагааны тайлагнал, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулсан болон ногдол ашиг тараалтын байдлыг хамруулан ойлгодог.

**Зураг 9. Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан хувьцаат компанийн тоо**



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


**Зураг 10. Санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд ирүүлсэн компанийн тоо**



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2018 оны хагас жилийн байдлаар 25 хувьцаат компани ногдол ашиг тараах шийдвэр гаргасан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад даруй 2 дахин нэмэгдсэн үзүүлэлт юм.

**Зураг 11. Ногдол ашиг тараасан хувьцаат компанийн тоо**




\*2018 оны хагас жилийн байдлаар ногдол ашиг тараах шийдвэр гаргасан компанийн тоо

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Манай орны хөрөнгийн зах зээлийн хувьд ногдол ашиг тараасан компанийн тоог нийт бүртгэлтэй хувьцаат компаниудын тоотой харьцуулахад 10 хүрэхгүй хувь нь ногдол ашиг тарааж байгаа бөгөөд тараасан хөрөнгийн дүн огцом савалгаатай, уул уурхай, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэх салбарын аж ахуйн нэгжүүд болох “Таван толгой”, “АПУ” ХК зэрэг компаниудын тараалтын хэмжээ ихээхэн нөлөөлж байна.

**Зураг 12. Тараасан ногдол ашгийн үнийн дүн /гэрбум төгрөг/**



\*2018 оны хагас жилийн байдлаар тараахаар шийдвэр гаргасан хэмжээ

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*


## 2.2. Зохицуулалттай этгээд

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн дагуу Хороонд бүртгүүлсний үндсэн дээр болоод Хорооноос тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа эрхэлж буй үнэт цаасны арилжаа эрхлэх 2, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх 1, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банкны үйлчилгээ үзүүлэх 3, хөрөнгө оруулалтын менежментийн 17 компани, хувийн хөрөнгө оруулалтын сан 12, хөрөнгө оруулалтын зөвлөх 14 байна.

2018 оны хагас жилийн байдлаар үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн хүрээнд Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй 54 компани мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Тэдгээрээс 22 компани андеррайтерийн эрхтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

**Зураг 13. Мэргэжлийн оролцогчдын тоо, тусгай зөвшөөрлийн чиглэлээр**






Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хорооны 2016 оны үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тогтоох тухай 94 дүгээр тогтоол 2017 оноос хэрэгжиж эхэлсэн явдал нь мэргэжлийн оролцогчдын нийт хөрөнгө болон өөрийн хөрөнгийн дүнд тус тус эерэг нөлөө үзүүлжээ.


**Зураг 14. Нийт хөрөнгийн дүнг мэргэжлийн оролцогчдын тоотой харьцуулсан байдал**



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Ашигт ажиллагаа нэмэгдэхэд зардлын бууралт гол нөлөө үзүүлсэн.

**Зураг 15. Мэргэжлийн оролцогчдын тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал**



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Үүний зэрэгцээ үнэт цаасны зах зээлд оролцогч компаниудад үйлчилгээ үзүүлэх, Хороонд бүртгэлтэй хуулийн үйлчилгээ үзүүлэх 23, аудитын үйлчилгээ үзүүлэх 54, хөрөнгийн үнэлгээний 23 компани үйл ажиллагаа явуулж байна.


**Зураг 16. Үнэт цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэгч байгууллагын тоо**



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Мөн Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн дагуу Хорооноос тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа эрхэлж буй хөдөө аж ахуйн түүхий эдийн арилжаа эрхлэх 1, болон брокерын 13 компани байна.

**Зураг 17. Хөдөө аж ахуйн түүхий эдийн брокер**




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

### 3. ЗАХ ЗЭЭЛ ДЭХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭРЭЛТ БА НИЙЛҮҮЛЭЛТ

#### 3.1. Хөрөнгө оруулагчдын данс ба арилжааны бүтэц

“ҮЦТХТ” ХХК-д өссөн дүнгээр нийт 934,572 данс, 148,473 холболтын данс байгаа бөгөөд 2018 оны хагас жилд улиралд нийт 28,456 данс шинээр нээгджээ.


**Зураг 18. ҮЦТХТ-д шинээр нээгдсэн дансны тоо**



Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

2013 оноос эхлэн эдийн засгийн нөхцөл байдал, гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал зэргээс хамааралтайгаар гадаадын хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох хэмжээ буурсан байна.

**Зураг 19. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь**




Эх сурвалж: “Арилжааны төлбөр тооцоо” ХХК

### 3.2. Үнэт цаасны арилжаа

2018 оны хагас жилд нийт 77.9 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 434.3 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлт юм.

**Зураг 20. Үнэт цаасны арилжааны үзүүлэлт**




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

#### 3.2.1. Хувьцааны арилжаа

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК болон “Монголын үнэт цаасны бирж” ХК-аар нийтдээ 390.1 сая ширхэг хувьцааг 49.76 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 37.52 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм.

**Зураг 21. Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/**




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

### 3.2.2. Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-ны арилжаа

**Анхдагч зах зээлийн арилжаа:** 2018 оны хагас жилд ЗГ-ын анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй.

**Хоёрдогч зах зээлийн арилжаа:** ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжааг 276.0 мянган ширхэг үнэт цаас 27.5 тэрбум төгрөгөөр арилжигдсан.

Зураг 22. ЗГҮЦ-ны зах зээлийн арилжааны дүн ба нийт арилжаанд эзлэх хувь




Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

### 3.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

Хороо нь хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргагчид тусгай зөвшөөрөл олгох, үнэт цаасыг бүртгэхдээ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын дагуу хянадаг.

Зураг 23. Ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ҮЦТХТ-д бүртгэгдсэн) гаргасан байдал




Эх сурвалж: “МИК холдинг” ХК

### 3.4. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

2018 оны хагас жилийн байдлаар Хөдөө аж ахуйн биржийн арилжаагаар 3,938 тонн ноолуурын, 1,980.5 тонн хонины ноосны, 32.7 тонн тэмээний ноосны, 2,530.8 тонн ямааны завод ноосны, 937.5 тонн хонины завод ноосны, 14.5 тонн тэмээний завод ноосны, гэрээг тус тус арилжиж, нийт 443.5 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

**Зураг 24. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны үнийн дүн /тэрбум төгрөг/**




Эх сурвалж: “Хөдөө аж ахуйн бирж” ХХК

Бирж 2015 оноос эхлэн биржийн индекс тооцоолж олон нийтэд мэдээлж эхлэв. МАРИХ нь “Mongolian Agricultural Price IndeX” буюу “Монголын хөдөө аж ахуйн барааны үнийн индекс” нэрийн товчлол бөгөөд бирж дээр арилжиж байгаа бараа түүхий эдийн үнийг тусгай загвараар жигнэж тооцоолсон үнэ юм. Биржийн индекс нь сонгосон бүлэг бараа эсвэл салбар дахь барааны үнийг ерөнхий багцаар харах боломж олгодог.

МАРИХ индекс 4 дүгээр сарын 16-ны өдөр хамгийн их буюу 856,579.6 нэгж хүрсэн байна.

**Зураг 25. МАРИХ индекс**



Эх сурвалж: “Хөдөө аж ахуйн бирж” ХХК

**Хавсралт 1. Зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүд**

1. Зах зээлийн үнэлгээ, ДНБ, Хувьцааны арилжааны статистик үзүүлэлт

(тэрбум төгрөг)

Үзүүлэлтүүд	2011.И	2012.И	2013.И	2014.И	2015.И	2016.И	2017.И	2018.И
Зах зээлийн үнэлгээ	1,991.1	1,895.2	1,437.7	1,572.3	1,408.5	1,423.1	1,497.7	2,484.9
Зах зээлийн үнэлгээ/ДНБ*	20.4%	14.4%	8.6%	8.2%	6.3%	6.1%	6.3%	8.9%
Хувьцааны арилжааны дүн	46.3	60.9	12.3	12.9	5.7	13.2	12.2	49.8

\*Өмнөх жилийн эцсийн үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-д харьцуулсан дүн.

2. Үнэт цаасны зах зээлийн индексүүд

	2011.И	2012.И	2013.И	2014.И	2015.И	2016.И	2017.И	2018.И
ТОП-20 индекс	19,481.00	19,042.26	14,415.46	15,256.46	14,591.23	11,451.95	12,583.85	19,737.49

**Хавсралт 2. Үнэт цаасны зах зээлийн оролцогчид**

3. Хувьцаат компанийн өмчийн хэлбэр

Жил	Хороонд бүртгэлтэй			Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй		
	Хувийн өмчит	Төрийн өмчийн оролцоотой	Төрийн өмчит	Хувийн өмчит	Төрийн өмчийн оролцоотой	Төрийн өмчит
2015.И	245	26	32	205	13	19
2016.И	243	25	32	199	16	21
2017.И	251	19	31	199	16	21
2018.И	253	19	31	190	12	19

4. Хувьцаат компанийн хувьцааны бүтэц (тэрбум ширхэг)

	2015.И	2016.И	2017.И	2018.И
Төрийн мэдлийн бус хувьцаа	2.49	2.82	4.16	8.35
Төрийн мэдлийн болон орон нутгийн оролцоотой хувьцаа	2.55	4.20	2.85	3.05

5. Хувьцаат компаниудын засаглалын үзүүлэлтүүд

Огноо	Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан хувьцаат компанийн тоо	Санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд ирүүлсэн	Огноо	Ногдол ашиг тараасан хувьцаат компанийн тоо	Тараасан ногдол ашгийн үнийн дүн /тэрбум төгрөг/
2013	158	204	2013	28	11.32
2014	181	196	2014	26	51.08
2015	133	173	2015	15	2.49

2016	121	140	2016	27	14.99
2017	142	123	2017	27	69.57
2018.И	142	194	2018.И*	25	146.03

\*2018 оны хагас жилийн байдлаар ногдол ашиг тараах шийдвэр гаргасан компанийн тоо, тараах хэмжээ

6. Мэргэжлийн оролцогчдын тоо

(тусгай зөвшөөрлийн чиглэлээр)

	2015.И	2016.И	2017.И	2018.И
Брокер, дилер	63	62	61	54
Андеррайтер	24	26	22	22
Хөрөнгө оруулалтын зөвлөх	15	15	15	14
ХАА-н түүхий эдийн брокер	37	37	15	13
Аудитын компани	33	44	44	54
Үнэлгээний компани	19	20	20	23
Хуулийн компани	15	20	19	23

7. Мэргэжлийн оролцогчдын санхүүгийн үзүүлэлтүүд

(тэрбум төгрөг)

	2015.И	2016.И	2017.И	2018.И
Нийт актив	67.6	75.1	91	93.2
Эздийн өмч	49.2	63.1	69.8	73.2
ХНХ	33.4	48.2	52.4	54.7
Тайлант үеийн ашиг, алдагдал	0.4	-1.3	1.2	3

Хавсралт 3. Зах зээл дэх бүтээгдэхүүний эрэлт ба нийлүүлэлт

8. “ҮЦТХТ” ХХК-д нээгдсэн дансны тоо

	2011.И	2012.И	2013.И	2014.И	2015.И	2016.И	2017.И	2018.И
Шинэ данс	36,976	96,019	6,210	6,610	11,540	52,649	7,074	28,456
Холболтын данс	7,008	5,716	1,494	1,377	1,270	2,087	1,665	5,229

9. Хөрөнгө оруулагчдын арилжааны дүн

(тэрбум төгрөг)

Жил	Нийт арилжааны гүйлгээний дүн	Үүнээс:			
		Гадаадын ААН	Гадаадын иргэн	Дотоодын ААН	Дотоодын иргэн
2011.И	82.33	33.32	5.41	32.64	10.97
2012.И	61.20	51.65	2.18	2.04	5.33
2013.И	12.31	6.56	1.34	1.68	2.73
2014.И	12.91	1.59	1.18	4.29	5.86
2015.И	290.60	2.09	2.23	268.06	18.22
2016.И	73.78	1.06	1.75	63.51	7.46
2017.И	499.55	8.65	17.44	353.08	120.38

2018.II	78.52	2.90	4.49	47.43	23.71
---------	-------	------	------	-------	-------

10. Үнэт цаасны арилжааны дүн

(тэрбум төгрөг)

Жил	Нийт арилжааны гүйлгээний дүн	Үүнээс:			
		Засгийн газрын бондын гүйлгээний дүн /анхдагч/	Засгийн газрын бондын гүйлгээний дүн /хоёрдогч/	Хувьцааны гүйлгээний дүн	Компанийн бондын гүйлгээний дүн
2011.II	82.33	36.00	-	46.33	-
2012.II	61.20	-	0.0005	60.89	0.31
2013.II	12.29	-	-	12.29	-
2014.II	12.91	-	-	12.91	-
2015.II	290.60	283.39	1.48	5.73	-
2016.II	98.62	80.12	5.24	13.25	-
2017.II	512.26	433.90	60.12	12.23	6.00
2018.II	77.94	-	27.55	49.76	0.63

11. Ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас

Үнэт цаас гаргагч	Нийт гаргасан үнэт цаас	"ҮЦТХТ" ХХК-д бүртгэгдсэн	Зээлдэгчийн тоо
“МИК актив нэг ТЗК” ХХК	328.1	322.9	6,658
“МИК актив хоёр ТЗК” ХХК	224.8	222.1	5,29
“МИК актив гурав ТЗК” ХХК	328.5	324.6	6,593
“МИК актив дөрөв ТЗК” ХХК	459.4	452.3	9,51
“МИК актив тав ТЗК” ХХК	301.2	294.3	5,805
“МИК актив зургаа ТЗК” ХХК	267.8	261.7	5,188
“МИК актив долоо ТЗК” ХХК	299.6	293.8	5,414
“МИК актив найм ТЗК” ХХК	189.8	186.3	3,291
“МИК актив ес ТЗК” ХХК	137.5	137.2	1,719
“МИК актив арав ТЗК” ХХК	103.0	96.3	1,585
“МИК актив арван нэг ТЗК” ХХК	70.9	67.5	1,135
“МИК актив арван хоёр ТЗК” ХХК	272.3	262.4	4,439
“МИК актив арван гурав ТЗК” ХХК	190.3	190.2	3,039
“МИК актив арван дөрөв ТЗК” ХХК	145.3	139.2	2,340
“МИК актив арван тав ТЗК” ХХК	136.5	136.5	2,269
“МИК актив арван зургаа ТЗК” ХХК	117.1	117.1	1,979

12. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны үнийн дүн

(тэрбум төгрөг)

	2014.II	2015.II	2016.II	2017.II	2018.II
Арилжааны хэмжээ	450.3	298.1	317.1	424.2	443.5